

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

2020 оны 05 дугаар сарын 21- ны өдөр

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ
ГАЗАРТ АШИГЛАХ ХИЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС,
ХЭВЛЭМЭЛ МАЯГТ ХЭВЛЭН НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕР**

**Харьцуулалт/
гэрээний дугаар:**

МХЕГ/202001010

Улаанбаатар хот

ҮНИЙН САНАЛ АВАХ ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр:
“Хилийн хяналтын хуудас, хэвлэмэл маягт”
хэвлэн нийлүүлэх цахим тендер
Тендер шалгаруулалтын дугаар:
МХЕГ/202001011

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь Хилийн хяналтын хуудас, хэвлэмэл маягт хэвлэн нийлүүлэх цахим тендерт аж ахуйн нэгж байгууллагуудыг үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **www.tender.gov.mn** хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 1 жил буюу 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнтэй тэнцэхүйц байна.
2. **Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 1 жил буюу 2019 онд санал болгож буй үнийн дүнтэй тэнцэхүйц, ижил төстэй бараа нийлүүлсэн байх.

Үнийн саналыг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10:30 цагаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 11:00 цагт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын **хурлын танхимд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Засгийн газрын тохируулагч агентлаг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, ЗГ-ын XII байр, 211 тоот өрөө, Утас: 263406

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.pcsp.gov.mn

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | | |
|-------------------------------------|------|--|
| 1. Тендерийн цар хүрээ | 1.1. | Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (эдгээр бараа, материал болон тоног төхөөрөмжийг цаашид “бараа” гэх) худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| | 1.2. | Бараа нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна. |
| | 1.3. | Тендер нь шалгарсан нийлүүлэгч техникийн тодорхойлолтод нийцсэн барааг уг тодорхойлолтод заасан хугацаанд, заасан газарт хүргэх үүрэгтэй. |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр | 2.1. | Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. |
| 3. Эрх бүхий тендер оролцогч | | Тендер оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 4. Эрх бүхий бараа | 4.1. | Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТООЗ-ны 1.1-д дурдсан барааг худалдан авснаар төлнө. |

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

- | | | |
|--|------|---|
| 5. Тендерийн баримт бичгийн агуулга | 5.1. | Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ:
I ХЭСЭГ
Бүлэг 1. Тендер оролцогчид өгөх зааварчилгаа
Бүлэг 2. Тендерийн өгөгдлийн хүснэгт
Бүлэг 3 Тендерийн үнэлгээнд мөрдөх шалгуур үзүүлэлт
Бүлэг 4. Тендер шалгаруулалтын маягт <ul style="list-style-type: none">• Тендерийн маягт• Үнийн хуваарь• Тендерийн баталгааны маягт• Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт II ХЭСЭГ
Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт
III ХЭСЭГ
Бүлэг 6. Гэрээний ерөнхий нөхцөл
Бүлэг 7. Гэрээний тусгай нөхцөл
Хавсралт: Тендерийн урилга |
| | 5.2. | Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй. |
| | 5.3. | Тендер оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн |

6. Тендерийн баримт бичгийг тодруулах	6.1.	ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо ("утсан холбоо"-нд зөвхөн телекс болон факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө.
7. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах	7.1.	Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

8. Тендерийн хэл	8.1.	Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. ТББ-ийн Монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.
9. Тендерийн иж бүрдэл	9.1.	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ: Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
10. Тендерийн маягт болон үнийн хуваарь	10.1.	Тендерт оролцогч нь тендер шалгаруулалтын маягт (Бүлэг 4)-д заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.
	10.2.	Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа, түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарь ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэг буюу тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.
11. Хувилбарт тендер	11.1.	ТШӨХ-д өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.
12. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт	12.1.	Үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.
	12.2.	Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.
13. Тендерийн валют	13.1.	Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
14. Тендерт оролцогч эрх бүхий	14.1.	Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд: (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн

эсэхийг нотлох баримт	<p>үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,</p> <p>(б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;</p> <p>(в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.</p>
15.Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт	<p>15.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:</p> <p>(а) Хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4 дүгээр бүлэг дэх тохирох маягыг ашиглан ирүүлнэ;</p> <p>(б) санхүүгийн чадавхийг харуулах сүүлийн ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн баталгаажсан санхүүгийн тайлан;</p> <p>(в) гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;</p> <p>(г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;</p> <p>(д) Хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;</p> <p>(е) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;</p> <p>(ё) одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;</p> <p>(ж) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.</p> <p>(г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх;</p>
16.Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт	<p>16.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотолсон баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:</p> <p>(а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;</p> <p>(б) барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон</p>

<p>17.Тендер хүчинтэй байх хугацаа</p>	<p>бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана;</p> <p>(в) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;</p> <p>(г) Захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 18.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ. Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.</p> <p>17.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.</p>
---	--

Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

<p>18.Тендер хүлээн авах эцсийн хугацаа</p>	<p>18.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p>
--	---

Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

<p>19.Тендерийг нээх</p> <p>20.Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох</p>	<p>19.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.</p> <p>20.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараахь шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:</p> <p>(а) ТООЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;</p> <p>(б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;</p> <p>(в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагыг хангасан тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;</p> <p>(г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;</p> <p>(д) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх.</p> <p>20.2. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзол, тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санал болгосон бараа нь ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр</p>
---	--

хангаж буй тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ. Үүнд:

- (а) тендерт санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
- (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
- (в) зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

20.3. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

21. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур

21.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

22. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл

22.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрээ гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.

22.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

22.3. Захиалагч Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn цахим хуудсанд тендерийн нэр болон багцын дугаарыг дараахь мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ. Үүнд:

- 1) тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
- 2) тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
- 3) нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
- 4) тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
- 5) тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.

22.4. Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.

22.5. Тендер нь шалгарсан оролцогч ТООЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа гаргаж, гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсэн даруй захиалагч ТООЗ-ны 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож, энэ тухайг шалгараагүй бусад тендерт оролцогчид мэдэгдэнэ.

23. Захиалагч гэрээ байгуулах

23.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад

**эрх олгох
үед тоо
хэмжээг
өөрчлөх
24. Гэрээнд
гарын үсэг
зурах**

нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.

24.1. Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

24.2. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаантүүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

24.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТООЗ-ны 39.4-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

**25. Гүйцэтгэлийн
баталгаа**

25.1. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, ТШӨХ-д заасан тохиолдолд, гэрээний тусгай нөхцөлд тусгайлан заасан хэлбэр, дүнгээр ирүүлнэ.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ТӨӨЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Хилийн хяналтын хуудас, хэвлэмэл маягт хэвлэн нийлүүлэх № МХЕГ/202001011 тоот цахим тендер
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсөв- нийт 30,000,000.00 /Гучин сая төгрөг/
ТӨӨЗ 3.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12-16 дугаар зүйлд дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг баталгаажуулан ирүүлнэ.
Б. Тендерийн баримт бичиг	
ТӨӨЗ 6.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, ЗГ-ын XII байр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар- Ахлах нягтлан бодогч С.Бадамцэцэг, Утас: 263406 Тодруулгыг дээрх хаягаар албан бичгээр авна.
ТӨӨЗ 6.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын [5] хоногоос багагүй байна. Тодруулгын хариуг хүсэлт ирүүлсэн хаягаар /цахимаар, албан бичгээр/ хүргүүлнэ.
В. Тендер бэлтгэх	
ТӨӨЗ 8.1	Тендерийн хэл нь Монгол хэл байна. Гадаад хэл дээр ирүүлсэн бүх материалыг баталгаат орчуулгаар орчуулж баталгаажуулан хавсаргасан байна.
ТӨӨЗ 9-16	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: - Тендерийн маягыг ТББ-т заасан МАЯГТ №:ТШМ-1-ийн дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ. -Үнийн санал; Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу баталгаажуулж ирүүлнэ -Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; -Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. - Сүүлийн 1 жилийн хугацаанд гэрээний үүргээ ноцтой зөрчсөн эсэх талаар шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа,

	<p>шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын лавлагаа ирүүлэх;</p> <p>-Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тендерийн баримт бичгийн маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлэх;</p> <p>-Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг нийлүүлэх баталгааг ирүүлэх;</p> <p>- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;</p> <p>- Бусад нэмэлт шаардлага; -Загвар дээжийг захиалагчийн өгсөн загварын дагуу ирүүлээгүй тохиолдолд тендерийг үнэлэхгүй./ Зөвхөн өгөгдсөн 3 загвараар ирүүлэхэд хангалттай/</p> <p>- Үнийн хуваарийг баталгаажуулан ирүүлэх; МАЯГТ №: ТШМ-2А-ээр;</p> <p>- Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтад заасан хугацааны дагуу баталгаажуулан ирүүлнэ,</p> <p>- Сүүлийн 1 жил буюу 2019 оны санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт хавсарган ирүүлэх;</p> <p>- Сүүлийн 1 жил тус бүрд санал болгож буй үнийн дүнтэй тэнцэхүйц, ижил төстэй бараа нийлүүлсэн байх.</p> <p>-Харилцагч банкны тодорхойлолт /Хугацаа хэтэрсэн өртэй эсэх/</p> <p>Техникийн тодорхойлолт зөрсөн эсвэл ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерийн материалд Хувь хүний болон байгууллагын нууцын тухай хуульд заасан нийтэд ил болгох хориглосон мэдээлэл байгаа бол уг мэдээллийг ялган ирүүлэх ба мэдээллийг ил болгохыг хориглосон үндэслэлээ тайлбарласан байна.</p>
ТӨӨЗ 11.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”
ТӨӨЗ 13.1	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй тогтмол байна.”
ТӨӨЗ 13.1	Тендерийн валют: Төгрөг байна.
ТӨӨЗ 16.1	Барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт: Шаардлагатай. Нийлүүлэгчийн санал болгож буй бараа захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцэж буй эсэхийг харьцуулсан хүснэгт бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.
ТӨӨЗ 17.1	Тендер нээснээс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 15	Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 1 жил буюу 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын дундаж борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнтэй тэнцэхүйц байна
ТӨӨЗ 20	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Барааг нийлүүлсний дараах байнгын болон урсгал үйлчилгээний (засвар) хуваарийг бэлтгэж ирүүлэх. Бараа материалын чанарын баталгаат засварын хугацаа - тухай бүр
ТӨӨЗ 20	Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцно”
	Г. Тендер ирүүлэх
ТӨӨЗ 18.1	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул

	тендерт оролцогч нь өөрийн аж ахуйн нэгжийн үндэсний тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчдын гудамж, ЗГ-ын XII байр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ТӨӨЗ 18.1	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн дараах нэр, ялгах дугаарыг тодорхой бичнэ: № МХЕГ/202001011 Хилийн хяналтын хуудас, хэвлэмэл маягт хэвлэн нийлүүлэх Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.
ТӨӨЗ 18.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, ЗГ-ын XII байр; Давхар болон өрөөний дугаар: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2 давхар, хурлын заал; Огноо: 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10:30 цаг;
	Д. Тендерийг нээх, үнэлэх
ТӨӨЗ 19.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг: Үүнд: Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, ЗГ-ын XII байр; Давхар болон өрөөний дугаар: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2 давхар, хурлын танхим; Огноо: : 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 11:00 цаг;
	Е. Гэрээ байгуулах эрх олгох
ТӨӨЗ 21	Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний төсөлтэй танилцан гарын үсэг, тамгаар баталгаажуулж ажлын 6-аас доошгүй хоногийн дараа Захиалагчид хүргүүлнэ.
ТӨӨЗ 22-24	Нийлүүлэх барааны тоо тендерийн баримт бичгийн бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хэмжээнээс өөрчлөгдөх бөгөөд захиалагч гэрээ байгуулсаны дараа гэрээний үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн гэрээний хугацаанд хэрэгцээт хэмжээгээр захиална. Иймээс тендерийн үнийг харьцуулахдаа БАРААНЫ НЭГЖИЙН ҮНЭЭР үнэлнэ. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж, хамгийн бага үнэ /нэг хуудас хэвлэн нийлүүлэх/ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. Бараа тус бүрийг хэвлэн нийлүүлэх “НЭГЖИЙН ҮНЭ”-ийг тендерийн буюу гэрээний үнэ гэж ойлгоно.
Бусад	Нийлүүлэх маягыг загвар болгон ирүүлэх бөгөөд тендерт шалгарсан тохиолдолд дугаар, өнгө, мэдээлэл гэх мэт эх бэлтгэл дээр засвар хийх боломжтойг нотолсон албан тоот ирүүлэх.

Дөрөв: ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** “Хилийн хяналтын хуудас, хэвлэмэл маягт” хэвлэн нийлүүлэх
2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. /Маягтын загварыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/49 тоот тушаалаар батлагдсан журам, загварын дагуу мэдээллийг бэлтгэж ирүүлэх;
3. **Баглаа, боодол:** Маягтыг 100 ширхэг бүрээр нэг боодол болгон, 10 боодлыг нь нэг багц боодол /1000 ширхэг/ болгон савлана. Гэрчилгээний багц бүрийг тоос шороо, чийг нэвтрэхгүй цаасаар боох бөгөөд боодол бүрийн гадна талд сар бүрийн тэмдэглэгээ хийсэн байна.
4. **Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, ЗГ-ын XII байр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2 давхар, 210 тоот өрөө]
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хилийн хяналтын хуудас, мэдэгдэл	МХЕГ-ын 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/49 тоот тушаал		Ш	МХЕГ 210 тоот	2020.06.01	2021.06.01	
Хилийн боомтод хийсэн халдваргүйжүүлэлтийн төлбөрийн баримт	Сангийн сайдын 2018.11.02-ны өдрийн 253 тоот тушаал		ш				

Маягтын өнгө, будаг, бичлэг болон бусад шаардлагыг загварын дагуу бүрэн хангасан байна.

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

МАЯГТ №: ТШМ-1

ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэрийг оруул]**, энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн **[бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]**-г **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш **[моо]** хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.
3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт **[үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах]** **[Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул]** үзүүлнэ.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс **[моо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(А ангилал)

Огноо: _____
 НТШ-ын дугаар: _____
 Тендерийн урилгын дугаар: _____
 Хувилбарт тендерийн дугаар: _____
 Хуудасны _____ -ын _____ дугаар _____

ТӨӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	EXW нэгж үнэ	Нэр төрөл бүрийн EXW бүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨӨЗ-ны 15.9.(а).(3)-д шаардсан бол)	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэххувь	ТӨӨЗ-ны 15.9(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9)
Тендерийн нийт үнэ (10)									

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	4. 2	3	4	5	6	7	8
1	Хилийн хяналтын хуудас	75,000	Ш	Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт	Гэрээ байгуулснаас хойш 5 хоногт	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт	
2	Хилийн мэдэгдэл	150,000	ш				
3	Хилийн боомтод хийсэн халдваргүйжүүлэлтийн төлбөрийн баримт	40,000	Ш				

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн итгэмжлэл

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягыг бөглүүлсэн байна.Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна.ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: *[тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]*

НТШ-ын дугаар: *[оруул:тендер шалгаруулалтын дугаар]*

Хувилбарын дугаар: *[оруул:энэнь хувилбарт тендер бол ялгах дугаар]*

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Бид, *[оруул: үйлдвэрлэгч/ гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]*-д байршилтай *[оруул: үйлдвэрлэгч /гэрээт борлуулагчийн бүрэн нэр]* нь*[оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]*-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд, үүгээр *[оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр]* компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан *[оруул: барааны нэр ба товч тодорхойлолт]*, барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

5. Чадварын мэдээлэл ирүүлэх маягтууд

МАЯГТ №: ТШМ-5А

Санал болгож буй туслан гүйцэтгэгч

	Зүйл	Туслан гүйцэтгэгчийн нэр	Бүртгэгдсэн газар болон чадавхи

Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

1.	Гэрээний дугаар	
	Гэрээний нэр	
	Улсын нэр	
2.	Захиалагчийн нэр	
3.	Захиалагчийн хаяг	
4.	ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог	
5.	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн	
6.	Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн (гэрээ байгуулагдах эсхүл дуусгавар болсон үеийн мөнгөний нэгжээр илэрхийлсэн гэрээний дүн байна) Мөнгөний нэгж Мөнгөний нэгж Мөнгөний нэгж	
7.	Гэрээний дүн: _____; Туслан гүйцэтгэх гэрээ: _____; _____; Түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн: _____;	
8.	Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо	
9.	Гэрээ нь хуваарьт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах)	
10.	Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _____ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах)	
11.	Техникийн тусгай шаардлагууд.	
12.	Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн дундаж хувийн жин, тухайн эх сурвалжийг тусгах.	

Нэгдсэн хүснэгт: Одоо хэрэгжиж буй гэрээ

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр
--

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ. Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа	Дараагийн 6 сард нэхэмжлэх үнийн дүнгийн сарын дундаж
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Санхүүгийн чадавхи

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТООЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж буйг харуулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ. Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ. Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө. Татварын албанд тушаасан (захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

Банк	Банкны нэр	
	Банкны хаяг	
	Утас	Холбоо барих ажилтны нэр, албан тушаал
	Факс	Телекс

Сүүлийн (ТШӨХ-д заасан тоо) хүртэлх жилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр (хөрвүүлэх ханш нь тухайн жил бүрийн эцсийн байдлаар мөрдөгдөж байсан Монгол банкны зарласан ханш байна) илэрхийлнэ.

Санхүүгийн мэдээлэл /сая/	Сүүлийн (ТШӨХ-д заасан тоо) хүртэлх жилийн хугацаанд					Төлөвлөсөн: Дараагийн 2 жилийн хугацаанд	
	5	4	3	2	1	1	2
1. Нийт хөрөнгө							
2. Эргэлтийн хөрөнгө							
3. Нийт өглөг							
4. Эргэлтийн өглөг							
5. Татварын өмнөх ашиг							
6. Татварын дараах ашиг							

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТООЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг ханган гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр	Дүн
1.	
2.	
3.	
4.	

ТООЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 12 сар байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1. Загвар дээж ирүүлнэ./Захиалагчаас өгсөн загвараас 1 ширхэгийг ирүүлэхэд болно/
 - 1.2. Барааг жилийн туршид захиалагчаас шаардсан тоо хэмжээгээр хэвлэн нийлүүлнэ.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1 Энд заасан бичиг баримтыг барааг хүргэх газарт бараатай хамт захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан зарлагын баримт;
 - 2.2 Барааг захиалснаас хойш 3 хоног дотор нийлүүлнэ.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 6.1 Баталгаат засварын тусгай шаардлага.

Барааг жилийн туршид захиалагчид шаардагдсан тоо хэмжээгээр нийлүүлэх учраас техникийн тодорхойлолтод заагдсан бараа хэвлэн нийлүүлээгүй тохиолдолд 3 хоногийн дотор алдааг засварлан олгоно. Нийлүүлэгчийн буруутай үйлдлээс болж гарах зардлыг захиалагч хариуцахгүй.
5. Төлбөр (ГЕН – 7)
 - 4.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
6. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
 - 5.1 Алданги оногдуулах хувь: *3 хоног тутам нийлүүлэх барааны үнийн дүнгийн 0,05 хувиар*
7. Нийлүүлэх тоо хэмжээ
 - 6.1 Барааг 1 жилийн туршид захиалагчид шаардагдсан загвар, тоо хэмжээгээр хэвлэн нийлүүлнэ.
 - 6.2 Шинээр хийгдэх маягтны загварыг захиалагчийн санал болгосон тоо хэмжээгээр хийж, захиалагч эцсийн болгон баталгаажуулсны дараа хэвлэлтэд оруулна.
 - 6.3 Барааг захиалсанаас хойш 3 хоногийн дотор нийлүүлнэ.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]



ХИЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН АЛБА/ ХЭЛТЭС

Web: www.inspection.gov.mn
E-mail: border@inspection.gov.mn

МЭДЭГДЭЛ

Хяналтын хуудасны дугаар:
.....

Хяналт эхэлсэн 20___он ___сар ___өдөр, ___цаг ___мин, дууссан 20___он ___сар ___өдөр, ___цаг ___мин;

Экспортлогч / Илгээгч		Үйлдвэрлэгч, гарал үүсэл		Импортлогч / Хүлээн авагч	
Тээвэрлэлт					
Бараа ачигдсан газар		Тээврийн хэрэгслийн төрөл		Чингэлэг	
Барааны тодорхойлолт					
Барааны нэр төрөл		Тоо хэмжээ, нэгж		Барааны нэр төрөл	
Ачилтын үеийн хяналт			Хилийн боомтын хяналт		
Улсын байцаагчийн албан тушаал, овог нэр:			Улсын байцаагчийн албан тушаал, овог нэр:		
/гарын үсэг, тэмдэг/			/гарын үсэг, тэмдэг/		

ЭКСПОРТЛОГЧ НЬ ХИЛИЙН БООМТОД “МЭДЭГДЭЛ”-ИЙГ ШАЛГУУЛЖ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙЛГЭН, БАРААГ ХИЛЭЭР НЭВТРҮҮЛНЭ.



ХИЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН АЛБА/ ХЭЛТЭС

Web: www.inspection.gov.mn
E-mail: border@inspection.gov.mn

МЭДЭГДЭЛ

Хяналтын хуудасны дугаар:
.....

Хяналт эхэлсэн 20___он ___сар ___өдөр, ___цаг ___мин, дууссан 20___он ___сар ___өдөр, ___цаг ___мин;

Экспортлогч / Илгээгч		Үйлдвэрлэгч, гарал үүсэл		Импортлогч / Хүлээн авагч	
Тээвэрлэлт					
Бараа ачигдсан газар		Тээврийн хэрэгслийн төрөл		Чингэлэг	
Барааны тодорхойлолт					
Барааны нэр төрөл		Тоо хэмжээ, нэгж		Барааны нэр төрөл	
Ачилтын үеийн хяналт			Хилийн боомтын хяналт		
Улсын байцаагчийн албан тушаал, овог нэр:			Улсын байцаагчийн албан тушаал, овог нэр:		
/гарын үсэг, тэмдэг/			/гарын үсэг, тэмдэг/		

ЭКСПОРТЛОГЧ НЬ ХИЛИЙН БООМТОД “МЭДЭГДЭЛ”-ИЙГ ШАЛГУУЛЖ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙЛГЭН, БАРААГ ХИЛЭЭР НЭВТРҮҮЛНЭ.



№ _____
(хяналтын хуудасны дугаар)

№9.4.1.2 ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС
АГААРЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ИМПОРТЛОХ
ҮЕИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	Хууль тогтоомжийн нэр, заалт	Шаардлага	Шаардлага хангасан эсэх	
			тийм	үгүй
I. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ				
Эхэлсэн: 20__ он __ сар __ өдөр, __ цаг __ мин; Дууссан: 20__ он __ сар __ өдөр, __ цаг __ мин;				
1	ААҮАТЗТХууль 15.6.1, 15.6.3, 15.6.7, 15.11.6, 15.12.8, ХХБАБТХууль 15.4, ХХБАБЭИХДТБҮХЖЖурам 2.1.3.6, 2.1.3.7	Зохих тусгай зөвшөөрөлтэй		
2	ХХБАБЭИХДТБҮХЖЖурам 2.1.3.2	Экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээтэй	Гарал үүслийн	Анализ
3	ХХБАБЭИХДТБҮХЖЖурам 2.1.3.2	Гэрчилгээ нь монгол, англи, орос хэлний аль нэг хэл дээр үйлдэгдсэн	Монгол	Англи
4	ХХБАБТХууль 6.1.3, ХТХууль 10.3, ПХБАХШМУБАХБТАЖурам 1.8	Улсын бүртгэлд бүртгэгдсэн (ургамал хамгааллын бодис, химийн бордоо, ахуйн хортон шавьж ариутгал халдваргүйтгэлийн бодист хамаарна)		
5	ХХБАБЭИХДТБҮХЖЖурам 2.3.1	Худалдах, худалдан авах гэрээ эсвэл түүнтэй адилтгах баримт бичигтэй	Үйлдвэр-лэгчтэй	Бусад
6	СТҮТХууль 6.2, ХХБАБЭИХДТБҮХЖЖурам 2.1.3.3, MNS 5029:2011 стандарт 8.4	Шаардлагатай мэдээллийг агуулсан хор аюулын лавлах мэдээллийн хуудастай		
БАТАЛГААЖУУЛАЛТ				
Импортологч / Хүлээн авагч		Үйлдвэрлэгч, гарал үүсэл	Экспортлогч / Илгээгч	
Тээвэрлэлт		Тээврийн хэрэгслийн төрөл	Чингэлэг	Бараа буух цэг
Барааны тодорхойлолт		Барааны нэр төрөл		Тоо хэмжээ, нэгж
<input type="checkbox"/> Гүний хяналтад шилжүүлэх <input type="checkbox"/> Шийтгэвэр ногдуулах <input type="checkbox"/> Хураах				
Хяналт хийсэн улсын байцаагч Овог, нэр: Гарын үсэг:		Хүлээн зөвшөөрсөн Албан тушаал: Овог, нэр: _____ РД: _____ Утас: _____ Гарын үсэг: _____		

Сангийн сайдын 2018 оны 11 сарын
2-ны өдрийн 158 дугаар тушаалын
долоодугаар хэсэрт

ХИЛИЙН БООМТОД ХИЙСЭН ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН
ТӨЛБӨРИЙН БАРИМТ

Баримт №01

Халдваргүйжүүлэлтийн
хураамжийн хуудас

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Индекс:

Дугаар:

Хураамжийн үнэ: **1 000 төг**

Санхүүгийн тэмдэггүй бол хүчингүй

20... он ... сар ... өдөр

Халдваргүйжүүлэлтийн
хураамжийн хуудас

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Индекс:

Дугаар:

Хураамжийн үнэ: **1 000 төг**

Санхүүгийн тэмдэггүй бол хүчингүй

20... он ... сар ... өдөр

Баримт №02

Халдваргүйжүүлэлтийн
хураамжийн хуудас

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Индекс:

Дугаар:

Хураамжийн үнэ: **5 000 төг**

Санхүүгийн тэмдэггүй бол хүчингүй

20... он ... сар ... өдөр

Халдваргүйжүүлэлтийн
хураамжийн хуудас

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Индекс:

Дугаар:

Хураамжийн үнэ: **5 000 төг**

Санхүүгийн тэмдэггүй бол хүчингүй

20... он ... сар ... өдөр

Баримт №03

Халдваргүйжүүлэлтийн
хураамжийн хуудас

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Индекс:

Дугаар:

Хураамжийн үнэ: **15 000 төг**

Санхүүгийн тэмдэггүй бол хүчингүй

20... он ... сар ... өдөр

Халдваргүйжүүлэлтийн
хураамжийн хуудас

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Индекс:

Дугаар:

Хураамжийн үнэ: **15 000 төг**

Санхүүгийн тэмдэггүй бол хүчингүй

20... он ... сар ... өдөр

Баримт №04

Халдваргүйжүүлэлтийн
хураамжийн хуудас

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Индекс:

Дугаар:

Хураамжийн үнэ: **50 000 төг**

Санхүүгийн тэмдэггүй бол хүчингүй

20... он ... сар ... өдөр

Халдваргүйжүүлэлтийн
хураамжийн хуудас

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Индекс:

Дугаар:

Хураамжийн үнэ: **50 000 төг**

Санхүүгийн тэмдэггүй бол хүчингүй

20... он ... сар ... өдөр